

АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022-01-12

Удирдах зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 07 дугаар тогтоолоор баталсан Холбооны 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахаар Даатгалын тухай, Жолоочийн даатгалын тухай хуулиудын хамаарах заалтууд болон бусад холбогдох эрх зүйн актуудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

2021 онд, Удирдах зөвлөл 5 удаа хуралдаж, жолоочийн даатгалын санхүүгийн үйл ажиллагаанд хийх аудитын компанийг сонгох, Жолоочийн даатгалын сангийн 2020 оны үйл ажиллагааны үр дүнгийн тухай сонсч төсвийн гүйцэтгэл, аудитын дүгнэлт болон Чингис хаан банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банкин дахь хадгаламжийг хэрхэн шийдвэрлэсэн тухай, даатгагчдаас 2021 онд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг тогтоох саналын тухай, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 9/3061, 9/3270 тоот албан бичгээр ирсэн үүрэг чиглэл, 2022 оны төсвийн төлөвлөгөөг батлах зэрэг 11 асуудал хэлэлцэж 4 тогтоол гаргасан байна.

Удирдах зөвлөлийн хэлэлцэх асуудлыг холбогдох жолоочийн даатгалын сан, албаны удирдлагууд бэлтгэж Гүйцэтгэх захирлын хянан тохиолдуулснаар хуралдаанд танилцуулж хэлэлцүүлсэн болно.

Удирдах зөвлөлийн 2021 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн 01 тоот тогтоолоор Жолоочийн даатгалын сангийн Санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх компанийг сонгож аудитын дүгнэлт хийлгэж санхүүгийн бүртгэл, хөрөнгө зарцуулалт, хяналтын горим үнэн зөв хэрэгжиж байгааг баталгаажууллаа.

Цагдаагийн ерөнхий газар, Ийгл ТВ, ТВ9, МҮОНРТВ болон бусад хэвлэл мэдээллийн газрууд, даатгалын компаниудтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн 2021 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлж 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд санал хүргүүлээ.

Холбооны ажиллагсдын Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулж ажлын албаны хэмжээнд хэлэлцүүлэн Гүйцэтгэх захирлын 2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 02/06 дугаар тушаалаар “Албан журмын даатгагчдын холбооны хөдөлмөрийн дотоод журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж мөрдүүлж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газраас 2021 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 6/1275 тоот албан бичгээр ирүүлсэн “Жолоочийн даатгалын сангийн данс байршуулах, санхүүжилтийг төвлөрүүлэх, сангийн хөрөнгийг шилжүүлэх зарцуулах

журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах саналаа 2021 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 01/106 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Гүйцэтгэх захирлын 2019 оны 02/11 дугаар тушаалаар батлагдсан “Албан журмын даатгагчдын холбооны ажилчдын улирлын үйл ажиллагааг дүгнэх, үр дүнгийн урамшуулал олгох журам”-ыг шинэчлэн Гүйцэтгэх захирлын 2021 оны 06 дугаар сарын 02/18 тоот тушаалаар баталж баримтлан ажиллаж байна. Мэдээллийн сангийн болон орон нутгийн менежерүүд, Шуурхай албаны ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод зарим өөрчлөлт оруулав.

Холбооны орон нутаг дахь салбаруудын үйл ажиллагаанд хяналт тавьж, онлайн хурал зөвлөгөөн тогтмол хийж заавар зөвлөгөө өгч ажиллахын зэрэгцээ аймгууд дахь 20 салбарын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

2021 онд, бичиг хэргийн эргэлт нийт 705 байснаас, албан байгууллага, иргэдээс 295 албан бичиг, 39 өргөдөл, гомдол хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн албан байгууллага, иргэдэд нийт 371 албан бичиг явуулжээ. Дотоод үйл ажиллагаатай холбоотой Гүйцэтгэх захирлын 54 тушаал гарч биелэлтийг ханган ажиллалаа.

“Жолоочийн даатгалын тухай хууль”, “Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам”, “Жолоочийн даатгалын сангийн данс байршуулах, санхүүжилтийг төвлөрүүлэх, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам” болон бусад холбогдох эрх зүйн актуудад өөрчлөлт оруулах саналыг Санхүүгийн зохицуулах хороо болон бусад холбогдох ажлын хэсэг, байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу хугацаа хоцроолгүй 2021 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 01/106, 2021 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 01/211, 2021 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 01/243, 2021 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 01/252 болон бусад албан тоотуудаар илгээж байсан болно. */өөрчлөлт оруулах тухай санал хүргүүлсэн албан бичигт хавсралтаар илгээсэн танилцуулга, тооцоолол зэргийг хавсаргав./*

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн дагуу Гүйцэтгэх захирлын 02/367 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй тооллогын комисс ажиллаж Холбооны үндсэн хөрөнгийг эд хариуцагч тус бүрээр тоолж, баталгаажуулж гарын үсэг зуруулан эд хөрөнгийн картыг шинэчлэн бүртгэж актлах хөрөнгийн жагсаалтыг гаргалаа. */Тооллогын дүн, актлах хөрөнгийн жагсаалтыг хавсаргав/*

Холбооны 2021 оны бичиг баримтуудыг албан хэрэг хөтлөлтийн зааврын дагуу хадгаламжийн нэгж үүсгэн 35 боть баримтыг архивт шилжүүлсэн байна.

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:

НЭГ. ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТАЛААР:

Даатгалын тухай хуулийн 12¹ дүгээр бүлэгт, Жолоочийн даатгалын тухай хуульд заасан үндсэн эрх, үүргийг хэрэгжүүлэхэд хөрөнгө, санхүүжилт юу юунаас чухал. Жолоочийн даатгалын тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр нь Жолоочийн даатгалын сан юм.

Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 312/206 дугаартай хамтарсан тушаалаар даатгагчдын 2020 оны Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын орлогод тооцсон хураамжийн орлогоос 1,5 хувиар тооцон, 2021 онд жолоочийн даатгалын санд төвлөрүүлэв.

Жолоочийн даатгалын сангаас олгосон нөхөн төлбөрийн буцаан төлөлтийг жолоочийн даатгалын санд буцаан төлөх гэрээний үүргээ биелүүлээгүй, гэрээнд заасан хугацаандаа төлж барагдуулаагүй тохиолдолд Монгол банкны зээлийн мэдээллийн сангийн хар жагсаалтанд бүртгэх, шүүхийн шийдвэрээр эрэн сурвалжлах, шүүхэд шилжүүлэх зэрэг арга хэмжээ авч ажилласнаар нөхөн төлбөрийн буцаан төлөлт сайжирсан байна. /2021 онд хууль хяналтын байгууллагатай хамтран ажилласан ажлын гүйцэтгэлийн дэлгэрэнгүйг хавсаргав./

Холбооны орлого, 2021 оны гишүүний татварыг “Монре даатгал” ХХК -аас бусад 14 компани 14,0 сая төгрөг төвлөрүүлсэн.

Жолоочийн даатгалын сан болон нийт орлогын төлөвлөгөөг зохих эх үүсвэрээр бүрдүүлснээр хууль, журамд заасан үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд Холбооны удирдах зөвлөлөөс баталсан зардлын төсвийг зарцуулах, нягтлан бодох бүртгэлд тусгах, санхүүгийн тайланг үнэн гаргаж тайлагнах цогц ажиллагааг хэрэгжүүллээ. Холбооны 2020 оны жилийн эцсийн санхүү, татварын тайлангуудыг нэгтгэн гаргаж холбогдох газруудад хүргүүлэв.

2020 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх компанийг Удирдах зөвлөлийн хуралдааны тогтоолоор Бэст фортуна аудит ХХК-ыг сонгон хийлгэж, дүгнэлтийг холбогдох байгууллагад хүргүүлж, Өдөр тутмын “Өдрийн сонин”-д аудитлагдсан санхүүгийн тайланг нийтлүүлэн олон нийтэд мэдээллээ.

Тайлант хугацаанд холбогдох хууль, журамд заасан баримт бичгийг бүрэн хангасан 9 хохирогчид Жолоочийн даатгалын сангаас нийт 36,782.1 мянган төгрөгийн нөхөн төлбөр олгож 49,611.9 мянган төгрөгийн буцаан төлөлтийг жолоочийн даатгалын санд төвлөрүүллээ.

Ажилчдын сар бүрийн цалин хөлсний тооцоог хийж, Нийгмийн даатгалын байгууллагатай харилцаж, сар бүр тайлан гарган өгч тайлант хугацаанд жирэмсэн болон

амаржсаны чөлөө авсан, хөдөлмөрийн чадвараа түр алдсан ажилтнуудын холбогдох тэтгэмжийн тооцоог хийж тооцоо нийлэн нэхэмжилж, олголоо.

ХОЁР. ЖОЛООЧИЙН АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ, МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ТАЛААР:

Жолоочийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйл, 24.2 дахь хэсэгт заасан жолоочийн хариуцлагын даатгалтай холбоотой мэдээллийг төвлөрүүлэн нэгтгэх, хяналт тавих үндсэн үүрэгтэй мэдээллийн сан үндсэн үүргээ өөрийн боловсруулж нэвтрүүлсэн МИИС системийг ашиглан хэрэгжүүлж ажиллалаа.

Хуулийн хүрээнд, жолоочийн даатгалын мэдээллийн нэгдсэн сан нь 2014 оноос хойш даатгалын 15 компани, 40 даатгалын зуучаас Санхүүгийн зохицуулах хорооны баталсан даатгалын гэрээний стандарт, мэдүүлгийн маягтаар 6.310.234 /давхардсан тоогоор/ даатгуулагчийн мэдээлэл хуримтлуулснаас 2021 онд, 803.593 даатгуулагчийн хийсэн гэрээний мэдээлэл /хүчинтэй, хүчингүй гэрээ хийж системд хандсан дүн/, 23.981 хохирогчийн мэдээлэл, 280.999 хохирогчид холбогдох даатгуулагч, нөхөн төлбөрийн /цэвэр+бохир/ мэдээлэлтэй болж баяжсан байна. Жолоочийн даатгалын тухай хуулийн 24.5 дахь заалтад зааснаар даатгалын зууч 40 хуулийн этгээд мэдээллийн сангийн мэдээллийг төлбөртэй ашиглаж байна. Жолоочийн хариуцлагын даатгалын гэрээ хийхтэй холбоотой мэдээлэл төвлөрүүлж хураамж тооцоолох, даатгалын баталгаа гаргах, даатгалын тохиолдлын дуудлага бүртгэх, даатгалд хамруулах, даатгалын тохиолдлыг бууруулах, сургалт сурталчилгаа хийх зэрэг үйлчилгээ үзүүлэхэд мэдээллийн сүлжээний тоног, төхөөрөмж, программ хангамж ашиглагдаж support үйлчилгээний лицензийн төлбөр төлж байнгын update хийж батлагдсан орон тоог цалинжуулж гишүүдийн төлөө үйлчилж байна.

Хуульд заасан мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, даатгагч, зуучдад үйлчилж ажиллахтай холбоотойгоор мэдээллийн сангийн хөгжүүлэлт, аюулгүй байдлыг хангах үүрэг нэмэгдэж хуулиар хүлээсэн үүрэгт заагаагүй боловч даатгагчдад МИИС, МИИС++ системээр үнэ төлбөргүй үйлчлэх, цахим даатгал хийх боломж бүрдүүлэх зэрэг 14 зорилтын хүрээнд 28 ажил төлөвлөж гүйцэтгэлийг ханган ажиллалаа.

Жолоочийн даатгалын мэдээллийн сан 2021 онд даатгалын үйл ажиллагааг цахимжуулахад өөрийн ашиглаж байгаа програм хангамж, сүлжээг боловсронгуй болгон хөгжүүлэх ажлын хүрээнд дараах ажил хийсэн байна. Үүнд:

- Төрийн мэдээллийн ДАН системтэй хамтран ажиллах гэрээ байгуулж мэдээллийн сангийн МИИС++ систем, гар утасны АЖД аппликейшныг холбох боломжтой боллоо.
- Мэдээллийн санд хийгдсэн мэдээлэл технологийн аудитын дүгнэлт, зөвлөмжийн дагуу холбогдох ажлыг бүрэн хийж сүлжээ, аюулгүй байдлын

түвшинг дээшлүүлэн зөвшөөрөлгүй хандалт хийж мэдээлэл хууль бусаар авч байгааг илрүүлэн таслан зогсоох, халдлагаас хамгаалах нэмэлт модуль суулгах, Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журамд өөрчлөлт оруулж Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулах, хэрэглэгчийн хандах эрх, админы эрхийн бүртгэлд тавих хяналтыг сайжруулах, өндөр эрхтэй хэрэглэгчийн системд хийсэн үйлдлийн лог бүртгэл хийх, зөвхөн зөвшөөрөгдсөн болон тест хийгдсэн өөрчлөлтийг үндсэн орчинд шилжүүлэх, ачаалал ихтэй үед хэрэглэгчийн хандалт хэвийн ажиллах тохиргоо хийх зэргээр зөвлөмжид заасан аудиторын асуулгын 40 ажлыг бүрэн хийж гүйцэтгэлээ.

- Аудитын зөвлөмж биелүүлэх, нийт ажилтнуудын ажиллах нөхцлийг сайжруулах зорилгоор системийн шаардлага хангахгүй байгаа компьютерүүдийг шинэчлэх, сайжруулах судалгааг гаргаж техник, тоног төхөөрөмжийн судалгаа, суурилуулалтын ажил, Microsoft office 365 хэрэглээний программыг ажлын тоног төхөөрөмж бүрт суулган, албан ёсны лицензийн идэвхжүүлэлтийг хийж нэмэлт шаардлагатай программ, системийг тохируулан хэвийн ажиллагаанд орууллаа.
- МИИС системд хийгдсэн нэмэлт хөгжүүлэлтийг ашиглан мэдээллийн санд даатгагчид, зуучлагдаас буруу мэдээлэл нийлүүлж байгааг удаа дараа илрүүлж засварлуулах шаардлагууд өглөө.
- 2021 онд жолоочийн албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх эрхтэй 15 даатгалын компани, даатгалын зуучлалын компаниуд 651.677 даатгалын гэрээ хийснээс 646.841 гэрээний мэдээллийг шалгаж 38.5% буюу 248.969 гэрээний мэдээлэл зөрчилтэй байгааг илрүүлсэн байна.
- Мастер шийдэл ХХК, Ай би эс ХХК-нд админ эрх олгож Нэйшнл иншур брокерс ХХК, Хэйва иншур брокерс ХХК компаниудтай МИИС систем ашиглах нэмэлт гэрээ байгуулж мэдээллийн санд бүртгэв.

Хууль журамд тусгагдаагүй боловч даатгалын үйл ажиллагаанд оролцогчийн хувьд хэрэгжүүлсэн ажлууд :

- Холбооноос олгосон нөхөн төлбөрийн эргэн төлөлтийн бүртгэл хяналтын програмыг шинээр боловсруулан ашиглалтанд оруулав.
- Замын хөдөлгөөний хяналтын удирдлагын төвийн хяналтын камераар зам тээврийн ослыг бүртгэх програм хийж програмын бүртгэх хэсэгт тохиолдол болсон огноо, зип код, байршил, улсын дугаар, тайлбар, шийдвэрлэлт, зураг оруулах линк гэсэн мэдээллийн талбарыг оруулсан. Мөн тохиолдол болсон огноо, улсын дугаар, зип код, байршил, тайлбар, шийдвэрлэлт зэргээр тухайн бүртгэгдсэн мэдээллээс хайлт хийх боломжтой болголоо.

- Жолоочийн хариуцлагын даатгалын тохиолдол, Тээврийн хэрэгслийн даатгалын тохиолдол, Нөхөн төлбөрийн лавлагаа, Санал, гомдол, Даатгалын компанийн утасны дугаар, хаяг байршил, Хууль тогтоомж, Мэдээллийн сангийн лавлагаа, бусад төрлүүдээр бүртгэх хэсгийн харагдах байдлыг сайжруулж нэмэлт өөрчлөлтийн МИИС системд оруулав.
- Даатгалын компаниудтай цахим шуудангаар албан бичиг, даатгалын мэдээ, тайлангаа солилцон 2020 он, 2021 оны тайлан, мэдээг 14 даатгалын компанитай тулган баталгаажууллаа.
- Тэнгэр даатгал компанитай даатгалын үйл ажиллагааг гар утсаар хийх шийдлээр хамтран ажиллах гэрээ байгуулж ДАН танилт нэвтрэлтийн бүртгэл хийх сервис хөгжүүлэлт хийлээ. Цахим даатгал хийх гэрээний дагуу тооцоолол хийх, бүртгэл хийх 3 сервисийг шинээр МИИС системд нэвтрүүлснээр жолоочийн даатгалын гэрээг цахимаар хийх боломжтой болж байна. ДАН системээр баталгаажуулсан даатгуулагч нарт цахимаар даатгалын гэрээ байгуулах нэмэлт программыг МИИС системд нэвтрүүлж Тэнгэр даатгал, Мастер зууч компаниуд цахимаар даатгал хийх боломжтой боллоо.

Холбоо анх байгуулагдсан цагаас Мэдээллийн сан нь жолоочийн даатгалын тухай хуульд заасан үүргийг биелүүлэхдээ олон төрлийн арга хэмжээг туршиж хэрэгжүүлж ажилласан байна. Мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэх үйл явц нь даатгагч нарын гар ажиллагаанаас хамааралтайгаар хуулийн хэрэгжилтийг хангах боломжгүй 2014 он хүртэл явж ирсэн нь түүхэн үнэн бөгөөд үүнийг жолоочийн даатгалын тухай хуулийн 24.2-т зааснаар мэдээллийн санд ирүүлдэг байсан даатгуулагч, даатгалын тохиолдол, хохирогчийн мэдээллийн тоон үзүүлэлтүүдээс харж болно.

Мэдээллийн сангаас даатгагчдад хууль хэрэгжүүлж ажиллах тухай байнга сануулж, алдаа, зөрчлийг баримттайгаар удаа дараа албан тоотоор илгээж шаардлага тавьж ажилласан ч үр дүнд хүрээгүй тул нэгдсэн нэг системд орж ажиллахаар шийдвэрлэн мэдээллийн санд МИИС системийг 2014 оноос нэвтрүүлсэн. Ингэхдээ даатгагч нарын гар ажиллагаагаар хийж байсан даатгалын хураамж тооцоолол, даатгалын гэрээний мэдүүлгийн маягт бөглөх, мэдээллийн санд илгээх, даатгалын баталгаа олгох, даатгалын хураамжийг даатгагчдад төвлөрүүлэх зэрэг даатгалын гэрээ байгуулах ажлын 86 гаруй хувь, даатгалын тохиолдол бүртгэх, дуудлага авах, дуудлага шилжүүлэх, мэдээллийн санд илгээх, нөхөн төлбөр олгохтой холбоотой нийт ажлын 20 орчим хувийг хуулиар үүрэг ногдуулаагүй ч даатгагчдын гүйцэтгэх үүргийг давхар хэрэгжүүлж өнөөдрийн мэдээллийн санг бүрдүүлээ. Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн дата өгөгдлөөр улсын хэмжээний даатгалын хэрэгжилтийн тайланг товхимол болгож нэгдсэн тайлан дүн, мэдээг улирлал, хагас жил, жилээр гаргаж нэгтгэдэг. Үүнд:

- Албан журмын даатгагчдын холбооны гишүүн 15 даатгалын компани 2021 оны 12 сарын 31-ний байдлаар жолоочийн даатгалын **699.077** хүчинтэй гэрээ байгуулж, **36.224.937.534** төгрөгийн даатгалын хураамж төвлөрсөн байна. Даатгалын гэрээний хувьд ангиллаар авч үзвэл хувь хүний **513.819**, хуулийн этгээдийн **169.474**, мэргэшсэн болон CD ангиллын жолоочийн **15.059**, дамжин өнгөрөхийн **725** гэрээ хийсэн байна.
- Нийт тээврийн хэрэгслийн 615,622 буюу 54,2% нь Улаанбаатар хотод бүртгэлтэй, 521,112 буюу 45,8% нь орон нутагт бүртгэлтэй байна.
- 2021 онд нийт **733,131** даатгалын гэрээ байгуулж, **38,183,466,964₮** төгрөгийн хураамж тооцоолсон боловч үүнээс **536,113** жолоочийн даатгалын гэрээ, **180,346** хуулийн этгээдийн даатгалын гэрээ, **15,919** мэргэшсэн CD-н даатгалын гэрээ, **753** дамжин өнгөрсөн тээврийн хэрэгслийн даатгалын гэрээ цуцлагдсан байна. Нийт **34,054** гэрээ цуцлагдсан ба нийт гэрээний **4,6%**-ийг эзэлж байна. Цуцлагдсан гэрээний нийт үнийн дүн **1,958,529,430₮** төгрөг байна.

2021 оны байдлаар жолоочийн даатгалд хамрагдалт өнгөрсөн онтой харьцуулахад гэрээний тоо **8,67%** -иар өссөн байна.

Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан нийт зуучлагч компаниуд 2021 оны **212,512** жолоочийн даатгалын гэрээ байгуулж, **10,105,083,887** төгрөгийн даатгалын хураамжийн орлого төвлөрүүлжээ. 2020 оны нийт хураамжийн дүнд эзлэх хувь **27.89%** байна. Үүнээс 7 банк даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр банкнууд нь нийт **28.397** гэрээ байгуулж, **999,473,232** төгрөгийн даатгалын хураамжийн орлого төвлөрүүлсэн байна.

Мэдээллийн сан нь Тэнгэр даатгал, Мастер зууч компаниудтай хамтран ажиллаж төрийн ДАН системийг ашиглан цахимаар даатгалын гэрээ хийх боломжийг бий болгоод байна.

Цахилгаан тэжээл, сүлжээ, хяналт, хөргөлтийн систем зэргийг цогц шийдвэрлэсэн нь олон улсын Tier III (**Redundant Components 99.982% Availability**) стандартыг хангаж байгаа бөгөөд Tier IV (**Redundant Components 99.995% Availability**) түвшинд хүрэх зорилгоор стратеги төлөвлөгөөндөө тусган ажиллаж байна.

ГУРАВ. ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН САНГААР ҮЙЛЧЛҮҮЛЭХ ИРГЭДЭЭС
ДААТГАЛЫН ТОХИОЛДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ ХҮЛЭЭН АВЧ,
ДААТГАЛЫН ТОХИОЛДЛЫГ ШУУРХАЙ ҮНЭН ЗӨВ ТОДОРХОЙЛОХ, НӨХӨН
ТӨЛБӨР ОЛГОХ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛЭХ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ ЖОЛООЧИЙН
ДААТГАЛЫН САНГИЙН ШУУРХАЙ АЛБА НЬ:

Жолоочийн даатгалын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-д заасны дагуу жолоочоос шалтгаалан гарсан зам тээврийн ослын талаарх мэдээллийг даатгуулагч, даатгагч, жолооч, хохирогч, иргэнээс хүлээн авч, даатгалын тохиолдлын улмаас хохирогчид олгох нөхөн төлбөрийг шуурхай, үнэн зөв тодорхойлох боломжийг бүрдүүлэн ажиллана гэж заасны дагуу шуурхай албаны ажиллах журмыг Санхүүгийн зохицуулах хороо /СЗХ/-ны 2015 оны 47 дугаар тогтоолоор баталсныг үйл ажиллагаандаа мөрддөг.

Тус журмаар Сангийн шуурхай алба нь жолоочийн даатгалын тохиолдлын талаарх мэдээллийг хүлээн авах, бүртгэх, дуудлагын ажилтанг ажиллуулах, даатгалын тохиолдлын газар дээр шуурхай очиж үзлэг хийх, тэмдэглэл үйлдэх, даатгалын тохиолдол болсныг баримтжуулах, даатгагч, жолоочийн даатгалын сангаас хохирогчид олгох нөхөн төлбөрийг үнэн зөв, тодорхойлж ажилладаг. Өөрөөр хэлбэл зам тээврийн осол /ЗТО/-ыг даатгалын тохиолдол мөн эсэхийг тодорхойлж шаардлагатай арга хэмжээг авч, зөвлөгөө мэдээллээр даатгагч, даатгуулагч, жолооч, хохирогчдыг үнэн зөв, тэнцвэртэй мэдээллээр хангах үүрэг хүлээдэг. Мөн, даатгалгүй, даатгалын гэрээний хугацаа дууссан жолооч зам тээврийн ослын улмаас бусдад хохирол учруулсан тохиолдолд даатгалын тохиолдлын газар дээр ажиллаж, хуульд заасан хугацааны дотор хүүгүй, барьцаагүй нөхөн төлбөрийг жолоочийн даатгалын сангаас гаргаж, хохирогчийг хохиролгүй болгох, Жолоочийн даатгалын тухай хуулийн 20.2-т зааснаар жолоочийн даатгалын санд эргүүлэн төлөх талаар ойлгуулан нөхөн төлбөр авах тохиолдолд буруутай этгээдтэй гэрээ хийж буцаан төлөлтийн хэрэгжилтийг хангадаг.

Шуурхай алба нь хууль, журамд заасан үндсэн үүргээ бүрэн биелүүлэхийн зэрэгцээ нийт даатгагч, даатгуулагч нарт түргэн шуурхай үйлчлэх, тэдний ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор нийслэлийн Замын хөдөлгөөний удирдлагын төв, Тээврийн цагдаагийн албаны алба хаагчидтай нягт хамтын ажиллагаатай ажиллаж зам тээврийн ослыг бууруулах, даатгалд хамрагдалтыг сайжруулах ажлыг санаачлан тодорхой хувь нэмэр оруулж ажилладаг.

2021 онд Жолоочийн даатгалын сангийн шуурхай алба нь 10 зорилтын хүрээнд 28 ажил төлөвлөж гүйцэтгэлийг ханган ажиллалаа. Үүнд:

1. Албан журмын даатгагчдын холбооны Удирдах зөвлөлийн 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор Албан журмын даатгагчдын холбооны Шуурхай албанд түр мөрдөх журам батлагдсан. Уг журмын 1.1 дэх хэсэгт “Энэхүү журмын зорилго нь жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын шуурхай албаны үйл ажиллагааны нийт дуудлагыг төвлөрүүлэн зохион байгуулахтай холбогдуулан даатгалын тохиолдлын бүх дуудлагыг нэг цэгт хүлээн авч түүний шийдвэрлэлтэд хяналт тавих ажлыг зохицуулахад

оршино” гэснийг удирдлага болгон ажиллаж байна. Жолоочийн даатгалын шуурхай алба зам тээврийн осол буюу даатгалын тохиолдлын нийт дуудлага төвлөрүүлэх, шуурхай дуудлагын төвөөр үйлчлэх зорилгоор 2019 оны 6 дугаар сарын 10-ны өдөр Харилцаа холбооны зохицуулах хорооноос 1800-1177 тусгай дугаарыг эзэмших зөвшөөрөл /бүртгэлийн гэрчилгээ/ авч Харилцаа холбооны зохицуулах хороотой тусгай дугаар ашиглах гэрээ байгууллаа.

Зам тээврийн осолд холбогдсон буруутай жолооч шуурхай дуудлагын нэгдсэн төвд хандсанаар жолоочийн хариуцлагын даатгалтай эсэхээ түргэн шуурхай мэдэж даатгалтай бол даатгагчтайгаа шууд холбогдох, Жолоочийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан үүргээ биелүүлэх боломжийг нь бүрдүүлж өгсөн.

Дуудлагын нэгдсэн төвийн үйлчилгээнд Callpro системийг ашиглах нөхцлийг бүрдүүлсэн. Энэ систем нэвтрүүлснээр дараах давуу талуудыг бий болгов.


- ЗТО-д холбогдсон жолооч аль ч даатгалын компанид даатгуулсан байсан 18001177 дугаарт дуудлага өгөх боломжтой бөгөөд жолоочийн хариуцлагын даатгалын зөвлөгөө мэдээллээр бүрэн хангагдаж, даатгалын компаниудын тусгай эрх бүхий ажилтан руу шууд холбон өгч үйлчилгээ үзүүлж байна.

- ЗТО-н талаар 18001177 дугаарт ирсэн бүх дуудлагын утасны дугаар, он сар, дуудлагын ярианы бичлэг автоматаар МИИС системд бүртгэгдэж, хадгалагдах тул эргэн сонсох боломжтой /дуудлага өгсөн эсэх маргаан үүсэхгүй/ болгосон.

- Ослын болон лавлагаа мэдээллийн дуудлагын бүх бичлэг мэдээллийн сангийн нөөц сервер дээр архивлагдана.

- Эрчим хүч тасрах болон дуудлагын нэгдсэн төвийн компьютер ажилгүй болсон үед 1800-1177 руу орж ирсэн дуудлага бүр автоматаар операторын гар утасруу холбогдох тохиргоотой болсноор дуудлага алдагдахгүй давуу талтай болгов.

Зам тээврийн ослын дуудлагын нэгдсэн төвийн үйлчилгээг схемчилж харуулбал:




Жолоочоос шалтгаалан гарсан зам тээврийн ослын талаарх мэдээллийг дуудлагын нэгдсэн төв дээр 24 цагаар ажилладаг 4 оператор 1800-1177, 7010-1177 утсаар, орон нутаг дахь салбарын менежерүүд тухайн орон нутгийн шуурхай дуудлагын утсаар тус тус даатгалын тохиолдлын дуудлага, бусад мэдээ, мэдээллийн чанартай дуудлага хүлээн авч даатгагч нарт шилжүүлэх, даатгалгүй, даатгалын гэрээний хугацаа дууссан жолоочийн ослын хохирол нөхөн олгуулахад нь туслах, зөвлөгөө мэдээллээр хангах, МИИС системд бүртгэх ажлуудыг гүйцэтгэж байна.

Нийт дуудлагыг хүснэгтээр харуулбал:

№	Дуудлагын төрөл	Нийслэлд	Орон нутагт	Бүгд
1.	Даатгалын тохиолдлын дуудлага	3904	21	3925
2.	Хууль, тогтоомжийн лавлагаа	646	562	1208
3.	Даатгалын сан, нөхөн төлбөрийн лавлагаа	927	366	1293
4.	Мэдээллийн сангийн лавлагаа	3306	1253	4559
5.	Санал гомдол	294	527	821
6.	Гишүүдийн хаяг, байршил	1130	1244	2374
7.	Бусад	1846	3735	5581
8.	Дүн	12053	7708	19761

Улсын хэмжээнд бүртгэгдсэн даатгалын тохиолдлын дуудлагын 61 хувь нь нийслэлд, 39 хувь нь орон нутагт бүртгэгдсэн байна.

Нийслэлд бүртгэгдсэн даатгалын тохиолдлын дуудлагын 23%-г Баянзүрх дүүрэгт, 16%-г Баянгол дүүрэгт, 17%-г Сонгинохайрхан дүүрэгт, 18%-г Хан-Уул дүүрэгт, 16%-г Сүхбаатар дүүрэгт, 8%-г Чингэлтэй дүүрэгт, 2%-г алслагдсан 3 дүүрэгт бүртгэгджээ.



2. Албан журмын даатгагчдын холбоо нь даатгалын шуурхай албаны үйл ажиллагааны хүрээг өргөтгөх, идэвхижүүлэх, даатгалын байгууллагаас даатгалын тохиолдлыг бүртгэх, үзлэг хийх, түргэн шуурхай шалган шийдвэрлэх, Жолоочийн даатгалын тухай хууль зөрчиж жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдаагүй, гэрээний хугацаа дууссан үедээ замын хөдөлгөөнд оролцдог зөрчлийг бууруулах чиглэлээр Замын хөдөлгөөний удирдлагын төвтэй хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж дараах ажил хийгээд байна.

- Нийслэлийн замын хөдөлгөөний хяналтын камерт бичигдсэн **2,809** зам тээврийн ослыг фото зураг болон дүрс бичлэгээр баримтжуулан, холбогдох даатгалын компаниудад мэдээлэл өгч, зам тээврийн ослын мэдээллийн түүх үүсгэн,

хөдөлгөөний түгжрэл саатлыг шуурхай арилгах зорилгоор даатгагчидтай ярилцаж зохицуулалт хийж ажилласан. Цаашид улам өргөжүүлэх боломж байгаа.


- Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдаагүй болон даатгалын хугацаа нь дууссан зөрчилтэй боловч хууль зөрчиж замын хөдөлгөөнд оролцож телекамерт бичигдсэн **57,167** тээврийн хэрэгслийн мэдээллийг баримтжуулан авч мэдээллийг шалгаж, **4,616** тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч жолооч нарт даатгалд хамрагдахгүйгээр хууль зөрчиж замын хөдөлгөөнд оролцож байгааг анхааруулах, гэрээний хугацаа дууссаныг сануулах мессэж хүргүүлсэн байна.

3. Замын цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажиллаж энэ хүрээнд Жолоочийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалгүйгээр замын хөдөлгөөнд оролцож байгаа жолооч нарыг шалган илрүүлэх, тэдний зөрчлийг арилгах, жолоочийн даатгалд хамруулах, холбогдох эрх зүйн актуудыг сурталчлах, даатгуулагч нарт мэдээ мэдээлэл өгч хуулийн хэрэгжилтийг хангуулах ажил хийж байна. Даатгалд хамрагдалтын байдлыг 2021 оны 10-р сард улсын хэмжээнд хяналт шалгалт хийв.

Уг шалгалтаар 12,226 тээврийн хэрэгсэл шалгаж жолоочийн даатгалгүй замын хөдөлгөөнд оролцсон 1,678 зөрчил илрүүлэн газар дээр нь даатгалд хамруулсан байна.

4. Цагдаагийн байгууллагаас олгодог цаасан суурьтай зам тээврийн ослын тодорхойлолтыг цахим хэлбэрт хөрвүүлж хохирогчид даатгалын байгууллага, цагдаагийн байгууллага дээр биечлэн очихгүй, үйлчилгээг зайнаас авах боломж бий болголоо. 2021 онд зам тээврийн ослын **15,347** тохиолдолд цахим тодорхойлолт гаргаж, гишүүн байгууллагуудын шуурхай алба, нөхөн төлбөрийн ажилтнуудыг зам тээврийн ослын мэдээллээр хангалаа.

5. Зам тээврийн ослын үед хүний амь нас, эрүүл мэнд хохироогүй, ослоос үүдсэн эд хөрөнгийн хохирлын талаар маргаангүй бол цагдаагийн байгууллага дуудахгүй, цахимаар зам тээврийн ослын зураг, бичиг баримтын зураг илгээж ослын дуудлагыг бүртгүүлэх, нөхөн төлбөрөө авах боломж олгосон ухаалаг гар утасны “АЖД” аппликейшныг хэрэглээнд нэвтрүүлэв. Өөрөөр хэлбэл Замын хөдөлгөөний дүрмийн 3.6-д заасны дагуу цагдаагийн албан хаагчийн оролцоогүйгээр шийдвэрлэх боломжтой нөхцөл байдал бүрдсэн тохиолдолд ашиглах боломжтой аппликейшн бий болгов. “АЖД” аппликейшнийг ашиглах зааврыг харуулбал:



Энэ технологийг ашигласнаар даатгуулж байгаа зүйлсийг баталгаажуулж, даатгалын луйврыг бууруулах, цаг, зардлыг хэмнэх, итгэлцлийг нэмэгдүүлж эрсдэлийн менежментийг ахисан түвшинд гаргасан. Ингэснээр даатгалын байгууллага шуурхай албаны зардлыг хэмнэх, ослын газар очих, ослыг баталгаажуулах гэж явах шаардлагагүй болж байна. Мөн “АЖД” аппликейшныг ашиглан даатгалын гэрээ, бүртгүүлсэн дуудлага, нөхөн төлбөр, материал бүрдүүлэлт гэх мэт даатгуулагч өөрийн мэдээллээ шалгах, хянах боломж бий болгов.

6. Жолоочийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т заасан хохирогчид олгосон нөхөн төлбөрийг буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх, жолоочийн даатгалын санд төвлөрүүлэх ажлыг шуурхай алба гүйцэтгэж 2020 оны эцсийн байдлаар жолоочийн даатгалын сангаас олгосон нөхөн төлбөрийн эргэн төлөлтийн үлдэгдэл 62 үүрэг гүйцэтгэгчид холбогдох үлдэгдэл байсан бол 2021 оны 12 сарын 31-ний байдлаар 28 үүрэг гүйцэтгэгч нөхөн төлбөрөө бүрэн төлж, 9 үүрэг гүйцэтгэгч шинээр нэмэгдэж 43 үүрэг гүйцэтгэгчид холбогдох үлдэгдэлтэй байна.

Нөхөн төлбөр буцаан төлөх үүрэг гүйцэтгэгч, тэдгээрийн батлан даагч нарын мэдээллийг МИИС системээс шүүж, даатгалын гэрээнд байгаа бүртгэлтэй хаягийн дагуу

хороодоор явах, оршин суугаа хаягийн бүртгэлийг шинэчлэннөхөн төлбөр буцаан төлөх үүрэг хүлээгчийг шүүхэд өгч, эрэн сурвалжлуулах, нэхэмжлэл гаргах зэргээр ажиллаж байна.

Шуурхай албаны хавтаст материалд байгаа үүрэг гүйцэтгэгч, тэдгээрийн батлан даагч нарын гэрээний мэдээллийн дагуу 29 батлан даагчид төлбөрөө төлөх, төлөхгүй тохиолдолд Монгол банкны зээлийн мэдээллийн санд бүртгэгдэх болсныг мэдээлсний дүнд зарим үүрэг гүйцэтгэгчид төлбөрөө бүрэн төлсөн. Мэдээллийн сангийн МИИС системд байгаа мэдээлэл, гэрээнд байгаа бүртгэлтэй хаягийн дагуу 1 дүгээр улиралд цар тахлын улмаас 2 хороогоор орж, оршин суугаа хаягийн бүртгэлийг шинэчилсэн бол 2 дугаар улиралд вакцин хийлгэж дархлаа тогтсоны дараа 40 орчим хороогоор орж хаяг бүртгэлийг шинэчилсэн. Үүний дагуу шүүхэд эрэн сурвалжлуулах, хариуцагчийг болон батлан даагчийг шүүхэд нэхэмжлэл гаргах боломж бий болгон ажиллалаа. Эрэн сурвалжлагдаж буй болон төлбөрөө хугацаанд нь төлөхгүй байгаа бүх хүмүүсийн боломжит батлан даагчдыг 100% шүүхэд шилжүүлсэн.

Шуурхай албаны операторуудын ажлын байрны чиг үүрэгт нөхөн төлбөрийн хугацаа хэтэрсэн хүмүүст болон хугацаандаа төлөгдөж байгаа гэрээний эргэн төлөлтийн өдөр болоход холбогдож эргэн төлбөр хийхийг сануулах ажлыг үргэлжлүүлэн хийж байна.

7. Зам, тээврийн хөгжлийн яамнаас нэвтрүүлэх гэж буй Авто тээврийн ухаалаг системийг дэмжиж бүртгэлийн цахим гэрчилгээ (RFID)-ний систем, Хаан даатгал компаниас санал болгосон Ай түүлс ХХК-ийн тээврийн хэрэгслийн хяналтын төхөөрөмж, системийг хооронд нь харьцуулсан судалгааг хийж танилцуулга гаргаж санал хүргүүлсэн байна.

2010-2020 онуудад зам тээврийн осолд өртөж амь насаа алдсан, хүнд, хөнгөн гэмтэл авч эрүүл мэндээрээ хохирсон тоо судалгаа, тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан, жолоочийн зөрчлийн оноо дуусч жолоодох эрхийг нь түдгэлзүүлсэн жолооч нарын судалгааг гаргаж нэгтгэлээ.

Ажлын бүтээмжийг сайжруулах, оновчтой болгох зорилгоор дуудлагын нэгдсэн төвийн 1800-1177 утасны дуудлаганд автомат хариу өгөх загварыг иргэдэд ойлгомжтой болгон өөрчиллөө.

Монгол улсад ашиглах мотоциклийн Автотээврийн хэрэгсэл-Мотоцикл-Ашиглалтад тавигдах ерөнхий шаардлага стандарт, Мотоцикл-Хайлшин обуд-Турших арга стандарт, D4 125 Мотоцикл техникийн ерөнхий шаардлага зэрэг 3 стандартад санал өгсөн.

Тээврийн хэрэгслийг гэрлийн гялбаанаас үүдэн гарах зам тээврийн ослыг бууруулах чиглэлээр тээврийн хэрэгслийн их гэрлийн автомат шилжүүлэгч электрон техникийн бүтээлийн эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS4598:2020 стандартын нэмэлт өөрчлөлт оруулах баримт бичгийн хоёрдугаар хувилбарыг зарчмын хувьд дэмжиж, MNS5011:2020 стандартад нэмэлт өөрчлөлт оруулах баримт бичгийн төсөлд санал боловсруулж хүргүүлсэн байна.

Даатгалын тохиолдлын дуудлага авах ажлыг 100% (24 цагаар дуудлага авах, дуудлага шалгах, цагдаа болон даатгагч нарт дуудлага шилжүүлэх, хяналтын камерт бичигдсэн зам

тээврийн ослыг баримтжуулах), нөхөн төлбөр олгох ажлын 50% (гар утасны “АЖД” аппликейшнээр баримтжуулах, даатгалын тохиолдлыг баталгаажуулах, хохирол тодорхойлох, цагдаагийн тодорхойлолт авах, нөхөн төлбөр олгох) -ийг цахимаар хийх мөн даатгалын луйвар гарах эрсдэлийг бүрэн хаах, даатгагч нарын зардлыг хэмнэх боломж бүрдүүлээд байгаа ч даатгагч нар бүрэн ашиглахгүй байна.

ДӨРӨВ. ДААТГАЛЫН ТОХИОЛДОЛ БУЮУ ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫГ БУУРУУЛАХАД ЧИГЛСЭН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ТАЛААР:

Санхүү эдийн засгийн их сургуулийн “Бизнесийн удирдлагын тэнхим”-ийн багш, оюутнуудын 14 аймгийг хамруулан санамсаргүй түүвэр судалгааны аргаар замын хөдөлгөөнд оролцож байгаа 2000 жолоочоос авсан “Жолоочийн даатгалын тухай хуулийн мэдлэг, ойлголтыг тодорхойлон судлах” судалгаа, “Албан журмын даатгагчдын холбооны маркетингийн үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлэх” судалгааны дүгнэлтүүдэд тулгуурлан 2021 оны сургалт, сурталчилгааны чиглэлийг тодорхойлж дараах ажлуудыг зохион байгуулж ажиллалаа.

Тээврийн цагдаагийн албатай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд орон нутгийн замуудад Мэдээллийн самбар хийж байршуулах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилготой “Яараад яахав дээ” “Дураараа биш дүрмээрээ”, “Ирээдүйгээ хамгаалья” зэрэг аяныг хамтран зохион байгуулж ажиллалаа.

18001177 тусгай дугаар “АЖД” апп-г хэрэглээг нэмэгдүүлэх, Жолоочийн хариуцлагын даатгалын талаархи мэдээ, мэдээллээр иргэдийг хангах зорилгоор аймаг бүрт хулдаасан самбар байыршуулж, сургалт сурталчилгааны тараах материал зэргийг бэлтгэн хэвлүүлж орон нутаг дахь салбаруудаар дамжуулан түгээж сурталчилж байна.

Тайлант хугацаанд дараах байгууллагуудад сургалт явууллаа.

Монголын зуучлагчдын холбооноос жил бүр зохион байгуулж явуулдаг Зуучлагчийн эрх олгох сургалтад “Жолоочийн даатгалын тухай хууль” болон Жолоочийн даатгалын гэрээ, хариуцлагын даатгалын талаархи сургалтуудыг 100 гаруй зуучлагч, төлөөлөгчийн эрх горилогчид, Санхүү эдийн засгийн их сургуулийн оюутнуудад явууллаа. Мөн, Талын монгол ТВ, Ийгл телевизийн ажилтнууд, Голомт, Тээвэр хөгжлийн банкны ажилтнуудад мэдээлэл өгч, сургалт явуулав.

Ийгл бродкастинг телевиз, Талын монгол телевиз, ТВ9 телевизийн “Гарц” нэвтрүүлгийг бэлтгэн хүргэдэг “Дижитон” студитэй хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллав. Мөн тайлант хугацаанд Монголын хамгийн олон сонсогчтой, улс даяар болон дэлхий дахинд мэдээллээ цацдаг “Эм жи эл” радио нь юс 88.3, Forbes Mongolia сэтгүүл,

Зарулем сэтгүүл, Vip76, eagle.mn сайтуудтай хамтран ажиллах гэрээ байгуулж, хамтын ажиллагааны хөтөлбөрийн дагуу ажиллалаа.

Ийгл телевизийн мэдээнд, Талын монгол телевизийн “Онцлох сэдэв”, ТВ9 телевизийн “Гарц” нэвтрүүлгүүдэд оролцож “Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудлуудын талаар”, Холбооны 2020 онд явуулсан үйл ажиллагаа, 2021 оны зорилго, зорилтын талаар мэдээлэл өгсөн болно. Мөн “Эм жи эл” радио 88.3-ийн “Зочны цаг” шууд нэвтрүүлэгт сар бүрийн эхний долоо хоногийн баасан гариг бүр Даатгалын сангийн дарга С.Хишигзаяа, Мэдээллийн сангийн дарга Т.Шинэцэрэг нар Жолоочийн даатгалын хуулийн хэрэгжилтийн талаар мэдээлэл өгч, даатгуулагч нарын сонирхсон асуултуудад хариулж, мэдээ, мэдээллээр ханган ажиллаж байна. Түүнчлэн МҮОНР-ийн “Соёмбо” нэвтрүүлэг, авто радио 96,3-д дээрх сэдвүүдийн хүрээнд ярилцлага өглөө. Мөн Шуурхай албаны дарга Б.Батзориг “Гарц” нэвтрүүлэгт, Ахлах ажилтан Б.Эрдэнэжаргал Талын монгол телевизийн “Онцлох сэдэв”, Монголын үндэсний радиогийн “Соёмбо”, Автордио 96,3-ын “Зочны цаг” зэрэг нэвтрүүлэгт, Мэдээллийн сангийн дарга Т.Шинэцэрэг ТВ9 телевизийн “Гарц” нэвтрүүлэгт тус тус оролцож мэдээ, мэдээлэл өглөө. Forbes Mongolia сэтгүүлд Мэдээллийн сангийн дарга Т.Шинэцэрэг оролцож “Жолоочийн хариуцлагын даатгалын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд Мэдээллийн технологийн үүрэг” сэдвийн хүрээнд нийтлэл, ярилцлагыг бэлтгэж нийтлүүлэв.

Гишүүдийн үйл ажиллагааг олон нийтэд хүргэх төлөвлөгөөт ажлын хүрээнд ТВ9 телевизийн “Гарц” нэвтрүүлгийн долоо хоног бүрийн даваа, бямба гаригуудад цацагдаж буй дугааруудад Ард даатгал, Бодь даатгал, Мандал даатгал, Тэнгэр даатгал ХХК болон Асимон брокер компаниудыг оролцуулж даатгуулагч нарт зориулан явуулж буй үйл ажиллагааг сурталчилан ажиллалаа. Мөн уг нэвтрүүлэгт Санхүүгийн зохицуулах хороо болон Автотээврийн үндэсний төв, Тээврийн цагдаагийн албанаас эрх бүхий албан тушаалтнуудыг оролцуулж Ковид 19 цар тахлын үед улсын хэмжээнд автотээврийн хэрэгслийн үзлэг оношлогоо хэрхэн явагдаж байгаа талаар болон цаг үеийн болон бусад асуудлаар тодруулга, мэдээ мэдээлэл бэлтгэж даатгуулагч нарт хүргэлээ.

Контент бэлтгэх ажлын хүрээнд, Ийгли телевиз, Талын монгол телевизийн мэдээгээр урсах хар титр, Ийгл ТВ-н зөвлөгөө контент, “Эм жи эл” радио 88.3-ийн “Радио хөтөч” нэвтрүүлгээр явуулах контентуудыг бэлтгэн олон нийтийн хүртээл болгож байна.

Хамтын ажиллагааны гэрээтэй байгаа Зарулем сэтгүүлд сар бүр 1800-1177 тусгай дугаар болон “АЖД” апп-ийг даатгуулагч жолооч нарт хүргэхэд чиглэсэн мэдээлэл бэлтгэн нийтлүүлж байна.

Фэйсбүүк хуудсаар дуудлагын нэгдсэн төв 18001177 дугаарын мэдээллийг нийтэд хүргэх ажлыг зохион байгуулж 10.189 хандалтаар мэдээлэл түгээлээ. АЖДХ-ны www.ami.mn цахим хуудаст хохирогчийн өргөдөл, буруутай этгээдийн өргөдөл, бүрдүүлэх материалын жагсаалт татаж авахаар байршсан талаар зөвлөгөөг өгч, info@ami.mn, shuurhaialba@ami.mn, Холбооны “АЖДХ” фэйсбүүк хуудсаар тус тус нөхөн төлбөрийн материал хүлээж авах боломж бүрдүүлж олон нийтэд мэдээлэв.

Дэлхий нийтийг хамарсан цар тахалтай холбоотой гарсан Засгийн газар, Улсын онцгой комисс, Аймгийн засаг даргын захирамж, Аймгийн онцгой комиссын шийдвэрийн дагуу олон нийтийг хамарсан сургалт зохион байгуулахыг хориглосон тул нийтийг хамруулсан сургалт зохион байгуулах боломжгүйгээс цөөн тооны, зорилтот бүлгийнхнийг хамруулан жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын тухай хуулийн ач холбогдол, нөхөн төлбөрийн материал бүрдүүлэлт, “АЖД” апплекейшнээр дамжуулан даатгалын тохиолдол бүртгэх, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгууллаа. */орон нутаг дахь салбарын тайланг хавсаргав./* Архангай, Баян Өлгий, Баянхонгор, Булган, Дархан уул, Дундговь, Дорнод, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүрбаатар, Сэлэнгэ, УвсХовд Хөвсгөл аймгууд дахь салбарын менежерүүд тухайн орон нутгийнхаа ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчид, такси үйлчилгээний жолооч нар, Ерөнхий боловсролын сургууль, Жолоочийн чадамжийн төв ТББ, Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, Насан туршийн боловсролын төв, Хүний эрхийн үндэсний комисс, Монголын Энместе Интернэйшнлийн салбар, Гэрэлт хөгжлийн тэмүүлэл ТББ, Насан туршийн боловсролын төв, Монгол банкны салбар, Улсын бүртгэлийн хэлтэс, Аймгийн засаг даргын тамгын газрын ажилнуудад, Их богд, Шинэ нэмэх, Авто 18 зэрэг авто жолооны курсийн сонсогч нарт, Булган Хангай МСҮТ-ийн оюутнуудад, Дорнын жолоо авто сургуулийн сонсогч, Авто тээвэр болон худалдаа үйлчилгээний Хан Хэрлэн ХК-ий ажилтан, албан хаагчдад, МСҮТөвийн ажилчдад, Моннис моторс ХХК-ийн Сүхбаатар аймаг дахь салбарын ажилчид, Илгээлтийн эзэд төслийн баг хамт олон, Боловсролын газрын ажилчид, Цайрт минерал ХХКомпаний жолооч нарт, Мөнгөн хүлэг, ТАУС авто сургуулийн сонсогч нарт тус тус Жолоочийн хариуцлагын даатгалбн талаар, ЖДТХуулийн хэрэгжилт, даатгалын гэрээний талаар сургалт зохион байгуулж мэдээ, мэдээллээр хангаж ажиллалаа.

Жолоочийн даатгалын тухай хууль, даатгалд хамрагдалтын ач холбогдлыг таниулах чиглэлээр 21 аймгийн орон нутгийн ТВ, радиогоор мэдээлэл түгээх, сэрэмжлүүлэг, сурталчилгааны гарын авлага тараах, тайлбарлан таниулах самбар байршуулах, сошиал, фэйсбүүк хуудсаар зохион байгуулж байгаа аяны талаарх мэдээ мэдээллийг түгээх, анхааруулга санамж өгөх, аймгийн төвд байрлах лед дэлгэцээр шторк, сурталчилгааг тогтмол цагт явуулах зэргээр сурталчилгааны ажлыг зохион байгууллаа.

ТАВ. ОРОН НУТАГ ДАХЬ САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

Албан журмын даатгагчдын холбооны Гүйцэтгэх захирлын 2017 оны 02/53 дугаар тушаалаар “Албан журмын даатгагчдын холбооны орон нутаг дахь салбарын ажиллах журам”-ыг баталсан. Журмын хоёрдугаар зүйлд салбарын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

1. Холбооны гишүүдийн орон нутаг дахь салбарын албан журмын даатгалын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, Холбоог бусад байгууллагын өмнө төлөөлөх,
2. Жолоочийн даатгалын тухай хуулийн дагуу даатгалын сан бүрдүүлэх, даатгалын сангаас хохирогчид олгох нөхөн төлбөрийн бүрдлийг хангах, олгосон нөхөн төлбөрийг буруутай этгээдээс буцаан нэхэмжилж төлүүлэх,
3. Замын хөдөлгөөнд оролцох тээврийн хэрэгслийг жолоочийн даатгалтай эсэхийг Холбооны МИИС программаас өөрийн эрхээр шүүх, лавлагаа гаргах, хяналт тавих
4. Даатгалын сангийн шуурхай албаны үүрэг гүйцэтгэх
5. Холбооны үйл ажиллагаа болон жолоочийн даатгалын холбогдох хууль тогтоомжийг олон нийтэд таниулах, сургалт сурталчилгаа явуулах
6. Төрийн болон төрийн бус байгууллага, даатгагч, даатгуулагч, иргэдтэй хамран зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах

Орон нутагт маркетингийн үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлэх судалгаа, Жолоочийн даатгалын тухай хуулийн мэдлэг, ойлголтыг тодорхойлох судалгаа, улсын хэмжээнд зам тээврийн ослын “хар цэг”-ийн судалгааг мэргэшсэн багаар хийлгэж дүгнэлт, зөвлөмж гаргуулж түүнийгээ үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллаж байна. Эдгээр судалгаанууд нь Холбооны болон орон нутаг дахь салбарын өнгөрсөн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлыг дүгнэсэн үнэлэлт, цаашид ажиллах чиглэл юм.

Холбооны гишүүдийн орон нутаг дахь салбарын албан журмын даатгалын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, Холбоог бусад байгууллагын өмнө төлөөлөх чиглэлээр:

Орон нутаг дахь салбарын менежер нь Албан журмын даатгагчдын холбоо болон Холбооны гишүүдийг төрийн болон төрийн бус байгууллагын өмнө төлөөлөн дараах байдлаар ажилласан байна.

- Аймгийн цагдаагийн газрын дэргэдэх Замын цагдаагийн тасагтай нягт уялдаа холбоотой ажиллаж даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтарсан хяналт шалгалтын төлөвлөгөөг батлуулан хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан.

- Аймгийн авто тээврийн төвтэй хамтран ажиллаж зайлшгүй шаардлагатай судалгааг тухай бүр нь авто тээврийн төвөөс авч ажлын албанд ирүүлж байсан. Мөн тээврийн хэрэгслийн улсын үзлэг оношлогооны үеэр сумдад томилолтоор ажиллан үзлэгт орж буй тээврийн хэрэгсэл жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдсан эсэхэд хяналт тавьж, даатгалд хамруулах шаардлага тавьж ажиллаж байна.

- Зам, тээвэр хөгжлийн сайдын 2020 оны А/222 дугаар тушаалаар батлагдсан “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ыг шинэчлэн баталсан. Журмын шинэчлэлтээр тээврийн хэрэгслийн **бүртгэл** хийхэд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээг заавал шалгах шаардлагагүй болсон нь хуулийн хэрэгжилтэд сөрөг нөлөөлөл үзүүлж эхэлсэн. Зам, тээврийн хөгжлийн сайдад Жолоочийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах тухай албан бичгийг удаа дараа хүргүүлсний үр дүнд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/136 тоот “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тушаалаар “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-д өөрчлөлт оруулсан. Салбарын менежерүүд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/136 тоот журмыг Авто тээврийн төвийн дарга, мэргэжилтнүүдэд танилцуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн.

- Холбооны гишүүдийн уялдаа холбоо хангах чиглэлээр нэгдсэн журмаар дархлаажуулалтад хамруулах, Авто тээврийн төвийн байранд “Нэг цэгийн үйлчилгээ”-г нэвтрүүлж даатгалын компаний ажилтныг суулгах болсон. Ингэснээр иргэд, жолооч, даатгуулагч даатгалд хамрагдах нь хүндрэл, чирэгдэлгүй ажиллах нөхцөл бүрдүүлж өгсөн.

- Дэлхий нийтийг хамарсан цар тахалтай холбоотой автотээврийн хэрэгслийн хяналтын үзлэгийн үеэр даатгалын компаний төлөөлөл авч явахгүй гэсэн маргаан нилээдгүй гарсан бөгөөд Авто тээврийн төвтэй уулзалт хийж цөөн тооны ажилтныг улсын үзлэгийн үеэр сумдад ажиллуулах зөвшөөрөл авч өгсөн нь зохих дэмжлэг болсон.

- Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд манай салбарын менежерүүд орж зам, тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажилласан.

- Жолоочийн даатгалын сангаас олгосон нөхөн төлбөрийг буцаан төвлөрүүлэх ажлын хүрээнд шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад Холбоог төлөөлөн ажиллаж байна.

Жолоочийн даатгалын тухай хуулийн дагуу даатгалын сан бүрдүүлэх, даатгалын сангаас хохирогчид олгох нөхөн төлбөрийн бүрдлийг хангах, олгосон нөхөн төлбөрийг буруутай этгээдээс буцаан нэхэмжилж төлүүлэх чиглэлээр:

Жолоочийн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2, 22.1.4 дэх хэсэгт заасан орлогыг Жолоочийн даатгалын санд бүрдүүлэх чиглэлээр ажилладаг байсан үүргээс 2020 оноос эхлэн хууль гарсан учраас чөлөөлөгдсөн.

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуулиар дээрх хоёр заалтыг хүчингүй болгосон учир орон нутгийн төсвөөс Жолоочийн даатгалын санд хөрөнгө төвлөрүүлэхгүй болсон.

2021 онд, орон нутгийн хэмжээнд Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр авахыг хүссэн нийт 9 өргөдөл хүлээж авсан. Үүнээс:

- Жолоочийн даатгалын тухай хуульд заасан үүргээ биелүүлээгүй үндэслэлээр нөхөн төлбөр олгохоос татгалзсан – 2
- Хохирлыг буруутай этгээд өөрөө барагдуулсан – 4 /нөхөн төлбөрийг буцаан төлөх тухай ЖДТХуулийн 20.2 дахь заалтыг тайлбарлахад буруутай этгээд төлбөрийг барагдуулсан/
- Шийдвэрлэлтийн шатанд – 2
- Тухайн тээврийн хэрэгсэл нь даатгалтай байсан – 1 байна.

Тайлант хугацаанд 3 иргэн төлбөрөө бүрэн төлж барагдуулсан бөгөөд 2 иргэн шүүгчийн захирамжид заасан хуваарийн дагуу буцаан төлөлтөө хийж байна.

Тайлант хугацаанд орон нутгийн хэмжээнд 279234 даатгалын гэрээ хийгдсэн байна.

Жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх чиглэлээр орон нутгийн Тээврийн цагдаагийн тасагтай хамтарсан хяналт шалгалтыг зохион байгуулж нийт 12226 тээврийн хэрэгслийг шалгаснаас 1678 даатгалгүй тээврийн хэрэгсэл илрүүлж 1642 тээврийн хэрэгслийг жолоочийн хариуцлагын даатгалд хамруулан 21 жолоочид зөрчлийн арга хэмжээ авахуулсан байна.

ЗУРГАА. ДҮГНЭЛТ:

2021 оны эхний хагас жилийн мэдээгээр нийт гэрээ нь 2020 оноос 38.907 гэрээгээр, 2019 оноос 67.633 гэрээгээр тус тус буурсан үзүүлэлттэй байсан нь АТҮТ-өөс сүүлийн 2 жилд зохион байгуулсан авто тээврийн хэрэгслийн бүртгэл, оношлогооны ажлын үед Жолоочийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалт, түүнийг хэрэгжүүлэх үүргийг Зам, тээврийн хөгжлийн сайдын баталсан журмаас хасч буруу сурталчилгаа хийж, хууль зөрчсөн үүрэг даалгавар өгч байгаатай холбон дүгнэж байсан. Тэгвэл ЗТХСайдын 2021 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн А/136 тоот тушаалаар ЖДТХуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалтыг хэрэгжүүлэх талаар гаргасан тушаалд нэмэлт өөрчлөлт оруулж Авто тээврийн үндэсний төвийн холбогдох ажилтнуудтай ажил хэргийн уулзалт зохион байгуулж

тээврийн хэрэгслийн гэрчилгээ шинээр олгох үед жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдсан эсэхийг хянадаг байх талаар харилцан ойлголцсноор жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдалт 2021 оны сүүлийн хагас жилд нэмэгдэж өмнөх онтой харьцуулахад 8,67 хувийн өсөлттэй гарсан нь тус Холбооны хүчин чармайлтын үр дүн юм.

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалыг цахимаар хийх боломж бүрдүүлснийг дэмжиж Жолоочийн хариуцлагын даатгалд хамруулах одоогийн нүсэр зохион байгуулалтыг өөрчилж зардал хямдруулах улмаар даатгуулагчдын төлөх хураамжийг эрс багасгах нөхцөл бүрдсэн байна.

МИИС системээс жолоочийн хариуцлагын даатгалын гэрээний хугацаа дуусч буй тээврийн хэрэгслийн өмчлөгчдөд даатгалын гэрээний хугацааг сануулах смс-мессэжийг автоматаар илгээх боломж бүрдүүлсэн бөгөөд жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт хангагдах нэг хөшүүрэг болсныг ашиглах нь зүйтэй. Мөн ЗХУТөвтэй гэрээ байгуулж ажилласны үр дүнд Жолоочийн даатгалд хамрагдахгүйгээр замын хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслийг илрүүлж даатгалд хамрагдах сануулга өгөх нөхцөл бүрдүүлснийг зохих хэмжээний зардлыг шийдвэрлэж ашиглах боломж бүрдсэн байна.

Жолоочийн хариуцлагын даатгалын гэрээ хийх ажиллагаа бүрэн цахимжсан, цахимаар даатгал хийх боломжтой болсон байтал цахимжаагүй мэтээр худал мэдээлэл тарааж бусдад буруу ойлголт төрүүлэх, Холбооны үйл ажиллагаа, хамт олны чармайлт, хүчин зүтгэлийг үгүйсгэх явдлын учир шалтгааныг тодорхой болгох, мөн ашгийн төлөө өрсөлдөөний зарчмаар үйл ажиллагаа явуулж байгаа даатгалын компаниуд Даатгалын тухай, Жолоочийн даатгалын тухай хуулиудын зорилтыг биелүүлэх, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах, зам тээврийн ослын улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хохирогчийн эрхийг хамгаалах нэг зорилгод нэгдэх боломжгүй нь сүүлийн үед хэвлэл мэдээлэл, сошиал ертөнцийн илэрхийлэл, жолооч нарын хандлагаас тодорхой байгаа нь жолоочийн хариуцлагын даатгалын ач холбогдлыг бууруулж байна. Иймд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалыг зам тээврийн салбарын бодлоготой уялдуулах, нөхөн төлбөр олгох үйл ажиллагааг олон улсын чиг хандлагыг харгалзан засвар үйлчилгээний байгууллагаар гэрээний дагуу гүйцэтгүүлж, хохирол үнэлэх, арилгах, барагдуулах ажлыг хохирогчдод бэлэн мөнгөөр олгох биш, оношлогоо, засвар үйлчилгээний байгууллагаар дамжуулж тооцдог болгох нь зохистой байна.

Зам тээврийн ослын улмаас хүний амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлыг үнэлж байгаа одоогийн практикийг өөрчилж эрүүл мэндийн байгууллага, эрүүл мэндийн

даатгалтай уялдуулж шийдвэрлэж байгаа олон улсын чиг хандлагыг судалж нэвтрүүлэх нь зүйтэй байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

ДААТГАЛЫН САНГИЙН ДАРГА,
ЕРӨНХИЙ САНХҮҮЧ
МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ДАРГА
ШУУРХАЙ АЛБАНЫ ДАРГА



С.ХИШИГЗАЯА
Т.ШИНЭЦЭРЭГ
Б.БАТЗОРИГ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:


АА-НЫ ДОТООД ХЯНАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ
АЖИЛТАН



Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ

ХЯНАСАН:

АЖДХОЛБООНЫ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.ЦЭВЭЭНЖАВ